

Рио Тинто Холдингс ХХК  
Улаанбаатар, Баянзүрх Дүүрэг,  
1-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 26,  
Сөүл Бизнес Төв 201 тоот  
Утас: (976-11) 450238  
Факс: (976-11) 450235  
2016 оны 09 сарын 27  
Дугаар: 2709/2016

### «1С:Enterprise» програм нэвтрүүлсэн тухай

2011 оны 3 сард байгуулагдсан “Рио Тинто Холдингс” ХХК нь Рио Тинто Группын гишүүн бөгөөд Англи улсад бүртгэлтэй Рио Тинто Минералс Девелопмент Лимитед (РТМД)-ийн охин компани юм. Манай компани нь ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагааг Монгол улсын бүх холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон олон улсын стандартад нийцүүлэн явуулдаг бөгөөд төсөл хөтөлбөрүүдээ орон нутагтай хамтран байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө хамгийн бага түвшинд байхаар төлөвлөж хэрэгжүүлдэг.

“Рио Тинто Холдингс” ХХК нь “1С:Enterprise” системийг нэвтрүүлэх болсон гол зорилго нь доорх бүртгэлийн асуудлуудыг програм дээр шийдэж, нягтлан бодогчийн ажлыг хөнгөвчлөх явдал байсан юм. Үүнд:

- Санхүү нягтлан бодох бүртгэл
- Татварын бүртгэл
- Толгой компаний тайлан
- Санхүүгийн тайлангууд
- Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан
- Татварын багц тайлангууд

Мөн бидний хувьд НББ-ийн програм болон Толгой компаний тайлангийн програм хоорондын мэдээлэл солилцоог бүрэн хийх, уг тайлангийн форматыг илгээх загварыг бэлнээр гаргаж авах нь нэн чухал байсан болно.

“Вансифорус” ХХК нь “1С:Enterprise” системийг манай компанид амжилттай нэвтрүүлсэн ба өнөөдрийн байдлаар систем хэвийн ажиллаж, бидний хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байгаа ба нэвтрүүлэхийн өмнө тавьсан бүх зорилтыг хэрэгжүүлж шийдсэнд бидний сэтгэл хангалуун байна.

“Вансифорус” ХХК-ийн зүгээс нэвтрүүлэлт, нэвтрүүлэлтийн дараах үйлчилгээ, системийн тасралтгүй сайжруулалт, системийн байнгын дэмжлэгийг чадварлаг, найдвартай багийн тусламжтайгаар байнга үзүүлж чаддаг.



  
У. САРАНЗУЛ